

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

2013 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

2013.04.25.

Улаанбаатар хот

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

1.1 Зохион байгуулсан ажлын талаар :

- Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 4 дүгээр сард 1 удаа зохион байгуулж, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг холбогдох хэлтэс албадаас авч нэгтгэн, www.ulaanbaatar.mn сайтад байршуулан ажиллаа.

- Нийт 23 хорооны Засаг нар болон Засаг даргын Тамгын газрын ажилтнуудад “Ёс зүй”-н чиглэлээр ШУТИС-н ахлах багш, магистр Д.Төрмөнхөөр лекц уншуулж, сургалт орсон.

- 2013.04.13-нд “Шинэчлэл бол-Сэтгэл гаргаж хийх ажил” сэдэвт уулзалтанд дүүргийн харъяа хэлтэс албадаас нийт 325 албан хаагч хамрагдсан.

- Төрийн албаны салбар зөвлөлөөс зарлагдсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд Тамгын газрын 35 албан хаагч, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хандаж төрийн албанд ажилд орох өргөдөл, хүсэлт гаргаж ажил горилсон иргэдийн жагсаалтад бүртгэгдсэн 84 иргэнийг уг шалгалтанд хамруулах ажлыг зохион байгууллаа.

1.2 Иргэдийн өргөдөл, санал хүсэлтийн талаар:

- Засаг даргын Тамгын газарт 4-р сарын байдлаар нийт 541 өргөдөл ирснээс шийдвэрлэгдсэн 420, шийдвэрлэх шатандаа 121 өргөдөл байна. Долоо хоног бүрийн Лхагва гаригт Засаг даргын иргэд хүлээн авах уулзалтаар гарч буй иргэдийн гомдол, санал, хүсэлтийг тэмдэглэл хөтлөн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

- Төрийн дээд шагналаар шагнуулахаар ирүүлсэн 43 иргэний материалын бүрдлийг хангуулан хүлээн авч, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хуралд танилцуулаад байна. Үүнээс 4 дүгээр сард 25 иргэний

шагналын материалыг зохих журмын дагуу тусгай программд шивж оруулан, 01/706 тоотгоор НЗДТГазарт шилжүүлсэн.

- Мөн дүүргийн харъяа байгууллага болон аж ахуйн нэгжийн 2 ажилтны тодорхойлолтыг холбогдох газарт дэмжсэн тоот явуулсан.

1.3 Тайлан мэдээ, хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн талаар:

- 4 дүгээр сарын байдлаар Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт нийт 270 албан бичиг ирсэн байна. Засаг даргын захирамж 46, Тамгын газрын даргын тушаал 65, албан бичиг 249 ширхэгийг тус тус бэлтгэн боловсруулсан байна.

- I улирлын Ёс зүйг мэдээг маягтаар гарган, yoszui@csc.gov.mn хаягаар илгээсэн.

1.4 Хэвлэл, мэдээллийн чиглэлээр:

- Дүүргийн www.bgd.mn вэб сайтанд тогтмол баяжилт хийн, цаг үеийн мэдээ мэдээллийг байршуулж, үүгээрээ иргэд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна. Тухайлбал, - “Автомашингүй өдөр”, “Баянголчуудын бямба”, мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулганыг угтсан “Оролцоог бодит болгоё” аяны хэвлэл мэдээлэл, сурталчилгааны ажлууд,

- Хотын захирагч Э.Бат-Үүл дүүргийн удирдлагууд болон Эдийн Засаг төлөвлөлтийн хэлтэс, гэр хорооллын хорооны засаг нартай уулзаж, Гандангийн дахин төлөвлөлтийн талаар санал бодлоо солилцсон тухай мэдээлэл зэргийг тус тус түгээсэн.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

2.1 Төсвийн орлогын талаар:

- 2013 оны 4 дүгээр сарын 25-ны байдлаар 10^{11} 10^9 10^6 10^3 3 тэрбум 3,1 сая 10^9 10^6 10^3 10^2 урьдчилсан байдлаар эхний 4 сарын орлогын төлөвлөгөө биелэх боломжтой байна.

2.2 Төсвийн зардлын гүйцэтгэлийн талаар:

- 2013 оны 4 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагад 6 тэрбум 113,8 сая, улсын төсвийн байгууллагад 12 тэрбум 331,3 сая төгрөгийн, бүгд 18

тэрбум 445,1 сая төгрөгний зарлагын санхүүжилт хийсэн. Төлбөр тооцооны мэргэжилтнүүд, төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нартай хамтран 2013 оны эхний 4 сарын олгогдсон санхүүжилтийн хүрэлцээ төсвийн тооцоо хийж, өр авлага гарах эсэх талаар судлан ажиллаж байна.

2.3 Мэдээ, тайлангийн талаар:

- Нийслэлийн өмчийн харилцааны газартай хамтарч Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, 21 өрхийн эмнэлэг, 7 төр захиргааны байгууллага, 18 сургууль, 30 цэцэрлэг өмч эзэмшлийн гэрээг 100 хувь байгуулж нийт 76 байгууллагын өмч хөрөнгийн нэгтгэл хийж, Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсэн.

- Нийт 109 төсөвт байгууллагын эхний 3 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч нэгтгэж, нийслэлийн төрийн санд хуулийн хугацаанд хүргүүлээ.

2.4 Бусад ажлын талаар:

- Орон нутгийн төсөвт тодотгол оруулах асуудлыг ИТХ-н хуралдаанаар батлуулсан. Төсвийн тодотголоор орон нутгийн орлогыг 2 тэрбум 50.0 сая төгрөгөөр, зарлагыг 3 тэрбум 546.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

- Дүүргийн 2012 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн ИТХурлын Төлөөлөгчидийн хуралдаанд өргөн барьж хэлэлцүүлэн, батлуулсан.

- Төсвийн тухай хуулийн 40.1-д заасны дагуу дүүргийн төсвөөс санхүүждэг төрийн болон төрийн бус өмчийн 109 байгууллагын төсвийн шууд захирагчтай Дүүргийн засаг дарга 2013 оны үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.

- Дүүргийн хэмжээнд 14706 ААН байгууллагын тайланг хүлээн авахаас 11006 ААН байгууллагын тайланг хүлээн авч нэгтгэлийг 3 сарын 4-нд нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

- Үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд 2013 ий 1 дүгээр улирлын санхүүгийн үйлдвэрлэл үйлчилгээний үзүүлэлтүүд хүлээн авч тулган үзүүлж байна. Өнөөдрийн байдлаар 9078 аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл үйлчилгээний үзүүлэлт хүлээн авч баталгаажуулаад байна.

Гурав. Үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

3.1 Байгаль орчин, агаарын бохирдлыг бууруулах ажлын талаар:

- 2013 оны 1-р сард Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг даргын “Агаарын чанарыг сайжруулах бүс шинэчлэн тогтоох тухай” 2013 оны А-13/А-30 дугаар хамтарсан тушаал, захирамж батлагдан гарч Баянгол дүүргийн гэр хорооллын 7, 9, 10, 11, 16, 20, 21, 22, 23-р хороодын айл өрхүүдийг боловсруулсан түлш болон бүрэн шаталттай ердийн зуух нэвтрүүлэх хосолмол бүсэд хамруулсан. Уг ажлын хүрээнд агаарын чанарыг сайжруулах хосолмол бүсэд “Роял Өүшн” ХХК-ийн гэрийн болон ханан пийшингийн “Дөл” зуух, “Хүрд” ХК-ийн нам даралтын усан халаалтын зуухнууд нийлүүлэгдэж байгаагаас 2013.04.20-ны өдрийн байдлаар нийт 5186 өрхөд зуухыг хөнгөлөлттэй үнээр борлуулаад байна.

- Агаарын бохирдлыг бууруулах дүүргийн салбар хороо нь 7 хоног бүр борлуулалтын цэгт ажиллаж боловсруулсан түлшний захиалга, мэдээ тайлан, тооцоог нийлж нэгтгэн, иргэдэд хүртээмжтэй хүрч байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж, борлуулагчидтай хийсэн гэрээний дагуу борлуулсан түлшний орлогыг дансанд төвлөрүүлж **449,668,000** /дөрвөн зуун дөчин есөн сая зургаан зуун жаран найман мянга / төгрөгийг Цэвэр агаарын санд тушаасан.

- Баянгол дүүргийн гэр хорооллын 9 хороонд нийт 12461 өрхөд боловсруулсан түлш түгээх цэгүүдээр дамжуулан 2013 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар үртсэн шахмал түлш **3602.3** тн, хагас кокосжуулсан түлш **4078.0** тн нийт **7680.3** тн түлш хүлээж авч борлуулсан.

- Бүрэн шаталттай, сайжруулсан зуух хүрээнд эрчим хүчний хэмнэлтэй, бүрэн шаталттай сайжруулсан зуух борлуулах, түгээх ажлыг эрчимжүүлэх зорилгоор хязгаарлалтын үндсэн бүсэд хамрагдсан хороодын хэсгийн ахлагч нарын дунд 1 сарын хугацаатай болзолт уралдаан зарласан бөгөөд уралдааныг дүгнэхээр хийгдсэн ажлын тайланг хэлэлцэж байна.

3.2 Орчны бохирдол, хог цэвэрлэгээний талаар:

- Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Дүүргийн хэмжээнд иргэдийг эрүүл, аюулгүй, цэвэр орчинд аж төрөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын А/86 дугаар захирамж гарч нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын гудамж талбайд үүссэн хог хаягдал, цас мөс, хальтиргаа гулгаа, нийтийн өмчийн эд хөрөнгийг тогтмол цэвэрлэх нийтийн их цэвэрлэгээг долоо хоног бүрийн Бямба гаригт 11.00-14.00 цагийн хооронд тогтмол хийж байхаар шийдвэрлэгдэж 4-р сард 4 удаагийн их цэвэрлэгээ зохион байгуулаад байна.

- Өнгөрсөн 4 удаагийн бямба гаригийн нийтийн цэвэрлэгээний тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж “ETV”, “За”, МҮОНТВ, “SBN”, “С1”, “MNC”, “Eagle”, “TV9”-үүдээр мэдээ бэлтгэж гаргасан ба дээрх телевизүүдээр

сурталчилгааны шторк бэлтгэн цацаж, www.news.mn, www.times.mn сайтуудад байршуулсан.

- 2013 оны 4-р сард зохион байгуулагдсан 4 удаагийн нийтийн их цэвэрлэгээнд давхардсан тоогоор 3800 байгууллага, аж ахуйн нэгжийн 16500 гаруй хүн оролцож цэвэрлэгээнээс үүссэн 650 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн.

- Баянгол дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран **”Эзэнтэй Монгол”** хөтөлбөрийн хүрээнд хороо бүрт цэвэрлэгээ хариуцсан 2-5 хүнийг урамшуулалтай ажиллуулж, дүүргээс хороо бүрийг цэвэрлэгээнд шаардлагатай багаж хэрэгсэл, хогийн саваар хангаж орчны хог хаягдлыг цэвэрлэх, эрүүл, цэвэр орчин бүрдүүлэн ажиллаж байна.

- Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн Дүүргийн нутаг дэвсгэрийн орон сууц, гэр хороолол, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх эрх бүхий этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Засаг даргын 2013 оны А/102 дугаар захирамжаар байгуулан хороодыг газар зүй, хүн амын онцлогт тохируулан 1, 2-р бүс болгон хувааж Дүүргийн харъяа хог тээвэрлэгч байгууллагын хог тээвэрлэх бүсийг тогтоон, бусад бүсүүдийн сонгон шалгаруулалтыг 2013 оны 03-р сарын 04-ний өдрөөс 03-р сарын 25-ны өдрүүдэд зарлаж Дүүргийн харъяа хог тээвэрлэгч байгууллага “Баянгол-Шинэ Өргөө” ОНӨААТҮГ-тай дүүргийн Засаг дарга “Хог ачиж цуглуулах, тээвэрлэх шууд гэрээ”-г байгуулж хог тээврийн үйлчилгээг явуулж байна.

- Хог тээвэрлэлтийн шинэчилсэн үнэ тарифийг ДИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2013 оны 30-р тогтоолоор батлуулж нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын төлбөр тооцоо болон хог тээвэрлэлтэд гарах аливаа харилцааг зохицуулахаар хог тээвэрлэлтийн шууд гэрээг аж ахуйн нэгж, байгууллагуудтай шинэчлэн хийж эхэлсэн.

- Нийслэл Улаанбаатар хотод 2013 оны 04 дүгээр сарын 27, 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын 7 дугаар бага хурал”-ын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулалтыг эрчимжүүлэх ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2013 оны А/184 дүгээр захирамжаар байгуулсан.

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн СӨХ-ны үйл ажиллагаа, хог хаягдал, рекламны байгууламж, орон сууцны хорооллын дээвэр болон лифтний засвар, гэрэлтүүлэг, зам талбайн засвар зэрэг 34 иргэний гомдол, санал, 31 албан бичгийг хүлээн авч асуудлыг шийдвэрлэсэн.

- 2013 оны 05-р сард зохион байгуулагдах “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байна.

Дүүргийн хороодоос дараах судалгааг авч нэгтгээд байна. Үүнд:

- зөвшөөрөлгүй баригдсан граж, контейнерийн судалгаа
- ногоон байгууламжийн хохирлын мэдээлэл
- зүлэгжүүлэх, мод тарих тохижилт хийх шаардлагатай нийтийн эзэмшлийн талбай болон БААН-үүдийн судалгаа

- дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг шатах тослох материалын худалдаа, үйлчилгээ явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийн судалгаа
- хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа нийтийн эзэмшлийн зам талбай, гэрэлтүүлэг, хайс, ногоон байгууламж, байрны фасад зэрэг объектын өнөөгийн байдлын талаар зурагжуулсан судалгаа зэрэг судалгаануудыг гарган холбогдох газруудад хүргүүлсэн.

3.3 Гэрэлтүүлгийн ажлын талаар:

- Баянгол дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд байрлах гэрэлтүүлгийн их засварын ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж “Ардчилсан орнуудын сайд нарын 7-р бага хурал”-ыг угтаж нийтийн эзмшил, орон сууц, гэр хорооллын гудамж зам талбайд байрлах гэрэлтүүлгийг 100% асалттай байлгах аар ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

- Их засварын ажлын хүрээнд:

1. Занабазар гудамны тэжээлийн кабель бүрэн шинэчлэх ажил
2. Ард аюушийн гудамжны гэрэлтүүлгийн толгойн шинэчлэл
3. Энэбиш гудамны гэрэлтүүлэгч толгой засвар
4. Сайхан төвөөс дээш өгсөх зам дагуу гэрэлтүүлгийн тэжээлийн кабель засварлах
5. Магсаржав гудамжны гэрэлтүүлгийн толгойн засвар үйлчилгээ
6. Энхтайвны өргөн чөлөө гудамжны гэрэлтүүлгийн толгой, тэжээлийн кабель шинэчлэл
7. Амарсанаа гудамжны толгой засвар
8. Сөүлийн гудамжны группийн кабель гэмтэл тогтоох
9. Далив худагт Дамдинбазар гудамжны толгой засвар, тэжээлийн кабель, удирдлагын шить засварлах гэх мэт засварын ажлууд бүрэн хийгдэж дууссан.

- Нийслэлийн инженерийн байгууламжийн хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу 04 дүгээр сарын 26-29-ний хооронд нийтийн эзэмшил зам талбайг 100% асалттай байлгах аар ажлын төлөвлөгөө, тухайн өдрүүдэд хариуцлагатай жижүүр ажиллуулах хуваарь гаргаж батлуулсан. Төлөвлөгөөний дагуу нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн асалтын хувь 04-р сарын 23-ны байдлаар 93%-тай байгаа бөгөөд төлөвлөгөөт хугацаанд 100% болгохоор ажиллаж байна.

3.4 Гадна зар сурталчилгааны байгууламжийн талаар:

- Баянгол дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байрлах гадна зар сурталчилгааны самбарын нэгдсэн тооллогыг дүүргийн Засаг даргын А/104 тоот захирамжаар явуулж 604 ш самбарын бүртгэл судалгааг гаргаж эзэн холбогдогчийг тогтоосон.
- Тус гудамж, зам талбайд байрлах самбарыг эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагад 2013 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр өөрийн эзэмшил бүхий

самбарыг буулгах тухай 05/516 тоот албан мэдэгдлийг 2013 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн.

- Мэдэгдэлд дурьдсан хугацаанд 9 аж ахуйн нэгж байгууллагын 79 ширхэг самбар буусан.

- Мэдэгдэлд заасан хугацаа дуусч шаардлага биелүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагын самбараас цагдаагийн камер халхалж байгаа 5ш самбарыг албадан буулгаж үлдэгдэл самбаруудыг аж ахуйн нэгж байгууллагын өөрсдийн зардлаар буулгуулахаар болсон.

- Дүүргийн хэмжээнд нийт 193 самбар буухаас одоогийн байдлаар 109 ш самбар буюу нийт буух самбарын 56% нь буусан байна.

3.5 Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:

- “Хүнсний тухай хууль”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль” шинэчлэн батлагдан 03-р сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Нийслэлийн ЗАА-наас гаргасан “Хүнсний салбарын эрх зүйн баримт бичиг” гэсэн 40 эмхтгэлийг томоохон аж ахуйн нэгжүүдэд тараагаад байна.

- 2013 оны 03 сарын 29-31-ний өдрүүдэд Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтарч Засаг даргын А/148 тоот захирамжийн дагуу удирдамж боловсруулах дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй саунуудад шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар 15 зөрчил илрүүлэн Мэргэжлийн хяналтын улсын байцаагч 13ы-г нь газар дээр нь арилгуулж, 2 байгууллагын үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар түр зогсоож 12 заалттай 3 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч 2 иргэнд холбогдох хуулийн заалтын дагуу 45,0 мян төгрөгийн шийтгэврээр захиргааны арга хэмжээ ногдуулсан.

- 3-р сарын 31-ний авто машингүй өдрөөр Энхтайвны өргөн чөлөөнд ажлаа танилцуулж гарын авлага материалаа тараан, худалдаа үйлчилгээний 8 газар нийтийн хоол, худалдаагаар үйлчиллээ.

- Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран нөөцийн мах худалдаалж буй дэлгүүрүүдэд шалгалт хийхэд 15 дэлгүүрээс Хуш тэрэг ХХКомпаний дэлгүүрийн нөөцийн мах худалдаалаад дууссан маргааш нь авах хуваарьтай байсан бусад 14 дэлгүүрт бүгд нөөцийн мах худалдаалж байв. Нөөцийн махны чанар харьцангуй сайн, борлуулалт нэмэгдсэн, бүх дэлгүүр нөөцийн мах худалдаалж байна гэсэн хаяг тавьсан байна. Дүүргийн хэмжээнд 4-р сарын 18-ны байдлаар 234,5 тн нөөцийн мах худалдаалаад байна.

- Цаг хэтрүүлэн ажилласан болон стандартын шаардлага хангахгүй 8 хүнсний дэлгүүр, 6 баар ресторан кафены согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

4.1 Боловсролын чиглэлээр:

- Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн мянган багш, Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Гантөмөртэй хамтран “Боловсролын чанарын шинэчлэл” зөвлөгөөнийг 2013 оны 04-р сарын 3-нд UB palace-ийн бага танхимд зохион байгуулсан.
- Шинэчлэлийн засгийн газрын “Зөв монгол хүүхэд” авьяас хөтөлбөрийн хүрээнд 600 гаруй хүүхдийн дунд “Аз жаргалтай өдрүүд” тоглолтыг 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулна.

4.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Оролцоог бодит болгоё” аяны хүрээнд:

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын, бодлого-шинэчлэл” үндэсний анхдугаар чуулганыг угтан зохион байгуулагдаж буй “Оролцоог бодит болгоё” аяны хүрээнд Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулганы нээлтийг 04 дүгээр сарын 11-нд хийлээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын арга хэмжээг 04 дүгээр сарын 13-нд зохион байгуулав. Хонхот бөмбөгийн тэмцээнд нэгдүгээр байранд 2 бүс, хоёрдугаар байранд 1-р бүс, гуравдугаар байранд 3-р бүс, эрэгтэй баг тамирчдаас нэгдүгээр байранд 1-р бүс, хоёрдугаар байранд 4-р бүс, гуравдугаар байранд 2-р бүс, Суугаа волейболын төрөлд нэгдүгээр байранд 2-р бүс, хоёрдугаар байранд 1-р бүс, гуравдугаар байранд 4-р бүс тус тус байр эзэллээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Оролцоог бодит болгоё” аяны хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөгийг 04 дүгээр сарын 14-ний өдөр “Өргөө” кино театрын урд талбайд 23 хорооны 150 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд гар урлалын үзэсгэлэн гаргасан бөгөөд 1000 гаруй ард иргэд өргөнөөр оролцсон.
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын, бодлого-шинэчлэл” үндэсний анхдугаар чуулганыг угтан “Оролцоог бодит болгоё” аяны хүрээнд Баянгол дүүргийн ЕБС-иудын захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг хамарсан сургалтыг 04 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга Т. Батдулам, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Тулга-5” студийн захирал Ш.Оргодол нар сургалтыг удирдаж лекц уншсан.
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгааллын бодлого-шинэчлэл” анхдугаар үндэсний зөвлөгөөнийг угтсан “Оролцоог бодит болгоё” сарын аяны хүрээнд Төмөр замын дээд сургуулийн урд талбайд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гар урлалын үзэсгэлэн худалдааг 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион

байгууллаа. Энэхүү арга хэмжээнд нийтдээ 60 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн урласан гар урлалаар үзэсгэлэн гаргасан.

- Баянгол дүүргийн 185 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гурил, будааны тусламж мөн эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг 04 дүгээр сарын 21-нд зохион байгуулсан.

4.3 Спортын чиглэлээр:

- Баянгол дүүргийн хэмжээнд ББХЧТТогтоох сорилыг 4 сарын эхний хагаст амжилттай зохион байгууллаа.

- Спортын байгууллагуудын дунд зохиогдох “АХА” тэмцээнийг 04 дүгээр сарын 12-нд амжилттай оролцсон.

- Оюутны спортын их наадмын улсын аварга шалгаруулах боксын тэмцээнийг 04 дүгээр сарын 10-15-ны хооронд баг тамирчидаа амжилттай оролцууллаа.

4.4 Халамж тусламжийн үйлчилгээний чиглэлээр:

- 15 хороонд нийт 67 иргэний гэрийн өргөдлийн дагуу судалгааг хийх талаар албан тоот хүргүүлж судалгааг нягтлан гаргаж байна.

- 7-р хорооны нийгмийн ажилтнаар ажиллаж байсан Баярмаагийн хүүхдээ эмчлүүлэх мөнгөн тусламжийг олгох ажил шийдвэрлэх шатандаа явагдаж байна.

- Дүүргийн Үндэстний цөөнхийн хүүхдийн судалгааг гарган Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газарт 04 дүгээр сарын 12-нд хүргүүлсэн.

4.5 Нийгмийн хариуцлагын чиглэлээр:

- Баянгол дүүрэг нь 2013 оныг “Нийгмийн хариуцлагын жил” болгон зарлаж, дүүргийн хэмжээнд нийгэм болон эдийн засгийн чиглэлээр олон нийтийн байгууллага болон бизнесийн байгууллагуудтай хамтран нийгэмд эерэг өөрчлөлт гаргах олон талын хамтын ажиллагааг хэрэгжүүлж эхэлж байна. Үүний нэг нь 2013 оны 04 дүгээр сарын 07-нд “Ази-фарм” ХХК–тай хамтран Эрүүл хүн их амжилт өдөрлөгийг дүүргийн ард иргэдийн дунд зохион байгуулсан.

- Улаанбаатар хотноо зохиогдох “Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг” зөвлөгөөнийг угтан 04 дүгээр сарын 20-нд Баянгол дүүргийн их дээд сургуулиудыг их цэвэрлэгээнд бүрэн хамрууллаа.

Тав. Цэрэг, иргэний хамгаалалтын талаар

- 2013 оны 1 дүгээр ээлжийн цэрэг халах, татах ажлыг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын А/347 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2013 оны А/168 дугаар захирамж гарч цэрэг халалт, татлагын бэлтгэл ажлыг хийж байна.

- Дүүргийн хэмжээнд зарлан дуудах хуудас 3500 иргэнд бичигдэж, тараалт 95,7 хувьтай байна.

- Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 29.1.3, 29.2 дахь заалт, Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргатай 2013 онд хамтран ажиллах гэрээний 4.1 дэх заалтын дагуу 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай “Мишээл хүү” ХХК-ийн “Мон Караван” авто сургуультай хамтран ажиллах гэрээг байгуулан Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын даргын 2013 оны 14 дүгээр тушаалаар тус дүүргийн Цэргийн штабын дайчилгааны офицер, дэд хурандаа С.Бүдрагчаа сургалтын төвийн захирлаар томилогдон ажиллаж, дайчилгааны бэлтгэл нөөцийн бага мэргэжилтэн, автын жолооч /ангилал ахиулах/ бэлтгэх сургалтыг зохион байгуулж байна.

- Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цэрэг, спортын “Дөл” тоглолт 2013 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Батлан хамгаалахын их сургуулийн байранд зохион байгуулагдаж, тус дүүргийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдаас цэрэг, спортын “Дөл” тоглолтонд түрүүлсэн 38-р сургуулийн “Сүлд” баг амжилттай оролцлоо.

- Зэвсэгт хүчний Жанжин штабаас “Энхийг сахиулагчдын өдөр”-ийг тохиолдуулан “Монгол цэрэг-Дэлхийн Цэрэг” уулзалт, өдөрлөгийг хуваарийн дагуу дүүргүүд дээр зохион байгуулахаар төлөвлөсөн. Уг арга хэмжээг тус дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цэргийн штаб 2013 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Төмөр замын дуу бүжгийн чуулгатай хамтран зохион байгуулав.

ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Т.НЯМЦЭЦЭГ

МЭДЭЭ ГАРГАСАН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ЭРДЭНЭГАВАА